



Г НЭР БҮХИЙ 309 ҮЛ ХӨДЛӨХ ЭД 7
ХӨРӨНГӨ ЗУУЧЛАЛЫН
БАЙГУУЛЛАГАД

САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ
ХОРОО

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26-44-44, Факс: (976-11) 32-90-84,
E-mail: info@frc.mn, <http://www.frc.mn>

2023.3.02 № ЦАТ-11/04/01

танай__-ны №_ -г

Г Мэдээлэл ирүүлэх тухай 7

Санхүүгийн зохицуулах хороо нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүргийн хүрээнд 2020 оны 120 дугаар тогтоолоор “Үл хөдлөх хөрөнгө зуучлалын байгууллагын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, эрх олголт, бүртгэлийн журам”-ыг Хорооны хуралдаанаар баталсан.

Тус журмын 2.1.6-д “брокер, агент нь Хорооноос баталсан сургалтын хөтөлбөрийн дагуу зохион байгуулагдсан сургалтад хамрагдаж, шалгалтад тэнцэж, гэрчилгээ авсан байх” гэсэн нөхцөл шаардлагын дагуу танай компани брокер, агентаа холбогдох сургалтанд 2023 оны 2 дугаар улиралд багтаан бүрэн хамруулж, гэрчилгээний хуулбарыг 2023 оны 7 дугаар сарын 05-ны өдрийн дотор багтаан Хорооны realestate-surgalt@frc.mn цахим шууданд ирүүлэхийг үүгээр мэдэгдье.

Хэрэв танай компани нь журмын шаардлага хангаагүй, өгсөн үүрэг даалгаврыг заасан хугацаанд биелүүлж ажиллаагүй тохиолдолд холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг анхаарна уу.

